



**“БҮС НУТГИЙН ЛОГИСТИКИЙН ТӨВИЙГ ХӨГЖҮҮЛЭХ МОН2719/0240 ТӨСӨЛ”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2018 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр / төслийн агуулга	Гүйцэтгэл			
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр огноо, шийдвэрийн дугаар зорилго /гэрээний дугаар баталсан сайдын тушаал/	“Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН2719/0240 төсөл” <u>Төслийн зорилго:</u> Монгол улсын импорт, экспорт, дамжин өнгөрөх тээврийн хэмжээг нэмэгдүүлж, дотоодын болон бүс нутгийн тээврийн эргэлтийг хурдасгах замаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх зорилгоор 2011 оны 01 сарын 03-нд Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хооронд санхүүжилтийн хэлэлцээрийг байгуулж, 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-аар “Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийг баталсан.			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	АХБ-ны зээл болон буцалтгүй тусламж / Улсын төсөв			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага / хэрэгжих нийт хугацаа	Зам, тээврийн хөгжлийн яам болон Төсөл хэрэгжүүлэх нэгж 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр			
4.	Төсөл хөтөлбөрийн зорилтууд	<ol style="list-style-type: none"> Худалдаа, тээвэр, логистикийн үйлчилгээг хөнгөвчлөх, олон улсын транзит тээврийг дэмжих, хил, гааль, мэргэжлийн хяналтыг хөнгөвчлөх, үр нөлөөг сайжруулах, Үндэсний зам, тээврийн сүлжээг өргөжүүлэх, олон улсын тээврийн системтэй холбох, Худалдаа, тээвэр, логистикийн үйлчилгээг хөнгөвчлөхөд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг нэвтрүүлэх, 			
5.	Зардал	<ul style="list-style-type: none"> Төслийн нийт санхүүжилт: /71.64 сая ам.доллар/ Азийн хөгжлийн банкны санхүүжилт: /45.0 сая ам.доллар/ Зээл 40.0 сая ам.доллар Буцалтгүй тусламж 5.0 сая ам.доллар МУЗГ-ын хөрөнгө оруулалт: /26,64 сая ам.доллар/ 			
	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Нийт төсөв	Гүйцэтгэл /2017 оны жилийн эцсийн байдлаар/	Гүйцэтгэл /2018 оны 4 дүгээр улирлын байдлаар/	Хувь
	Үүнд:				
	Барилгын ажлын санхүүжилт:	МУЗГ-ын батлагдсан төсөв Улсын төсвөөс 16,335,000,000 /төгрөг/	11,665,950,430 /төгрөг/	14,791,050 430,000 /төгрөг/	90,55%
Төслийн ажиллагааны зардал:	АХБ-ны буцалтгүй тусламж 1,379,167.94 /сая.ам.доллар/	1,155,377.54 /ам. доллар/	1,305,869.93 /ам.доллар/	94.69%	

	Зөвлөх үйлчилгээний зардал:	АХБ-ны буцалтгүй тусламжаас 1,355,540 /сая ам.доллар/	397,177.86 /ам. доллар/	1,067,942.98 /ам. доллар/	78.78%
	Логистикийн төвийн барилга угсралтын ажилд:	АХБ-ны зээлээс 32,400,313.00 /сая ам.доллар/	15,951,489.30 /сая ам.доллар/	28,622,639.80 /сая ам.доллар/	88.34%
6.	Логистикийн төвийн дохиолол холбооны ажилд:	АХБ-ны зээлээс 1,457,426.00 /сая ам.доллар/	-	1,030,181.00 /сая ам.доллар/	70.68%
6	Төслийн зорилт				
	<p><i>1-р зорилтын хүрээнд:</i></p> <p>Худалдаа, тээвэр, Логистикийн үйлчилгээг хөнгөвчлөх, Олон улсын транзит тээврийг дэмжих, Хил, гааль, мэргэжлийн хяналтыг хөнгөвчлөх, үр нөлөөг сайжруулах,</p> <p><u>Хүрэх үр дүн:</u> Монгол улсын импорт, экспорт, дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдэж дотоодын болон бүс нутгийн тээврийн эргэлт хурдсах, гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудын ажлын нөхцөл сайжрах, хяналт чанаржих, гаалийн байгууллагын хүчин чадал нэмэгдэх юм.</p>	<p>1. Төслийн хүрээнд баригдах логистикийн төвийн цогцолбор нь олон улсын транзит тээврийг дэмжих зориулалттай ба логистикийн төв нь авто машинаас галт тэрэг, галт тэрэгнээс авто машин, галт тэрэгнээс галт тэрэг рүү ачаа ачиж, буулгах мөн гаалийн баталгаат агуулах, гааль, мэргэжлийн хяналтын нэгдсэн үйлчилгээг бий болгох юм.</p> <p>Төсөл нь нийт 128 га талбайг хамрах бөгөөд чингэлгийн, хүнд даацын, агуулахын гэсэн 3 бүстэй байхаар төлөвлөгдсөн ба 50 тн даацтай 2 гүүрэн кран, механизмын засварын төв, өргөн болон нарийн царигийн ачилт буулгалтын 11,5 км орчим төмөр зам, ложистикийн төв рүү орох гарах төмөр замтай 2 түвшинд огтлолцох хүнд даацын тээврийн хэрэгсэл явах боломжтой гүүрэн байгууламж, 1,6 км авто зам тус тус барихаар төлөвлөгдсөн.</p> <p>Манай улс энэхүү логистикийн төвтэй болсноор хүртэх ашгийг өндрөөр тооцоолж байна.</p> <p>Тус ложистикийн төв нь баригдсанаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, барилга, уул уурхайн салбарын том оврын тоног төхөөрөмж болон манай улсын нутгаар дамжин өнгөрөх транзит ачааг шилжүүлэн ачих техникийн боломж нээгдэж байна. Энэ нь Монгол Улс төдийгүй бүс нутаг дахь тээврийн коридоруудтай манай улсын орц, гарц өрсөлдөх таатай боломжийг бүрдүүлэх юм.</p> <p>2. Логистикийн төвийн барилга угсралтын ажил тодорхой үе шаттай хэрэгжиж ирсэн бөгөөд одоогийн байдлаар логистикийн төвийн үйл ажиллагаанд 16,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий</p> <ol style="list-style-type: none"> 1) Логистикийн төвийг хангах эрчим хүчний шугам, дэд станцын барилга байгууламжийн ажил 2) 3,6 км цэвэр усны шугамын ажил 3) Төмөр замтай 2 түвшинд огтлолцох гүүрэн байгууламж, 1,6 км авто замын барилга угсралтын ажил 4) Холбооны 24 дэх худаг, 100 метр урттай 2 яндант сувагчлал, шилэн кабелийн төгсгөлийн PDF төхөөрөмж, шилэн кабелийн медиа конвертор, жампер кабель, 100 хосын холбооны терминал бокс, хананы хайрцаг зэргийг нийлүүлэх, угсарч суурилуулах гадна холбоо интернетийн шилэн кабелийн ажил 5) Логистикийн төвийн гадна цахилгаан /110 кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, Логистикийн төвийн дэд станцын өргөтгөл/ хангамжийн зураг төсөл боловсруулах ажил 			

- 6) Логистикийн төвийн гадна цахилгаан /110 кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, Логистикийн төвийн дэд станцын өргөтгөл/ хангамжийн барилга угсралтын ажил
- 7) Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ,
- 8) Логистикийн төвийн гадна хамгаалалтын хашааны ажил
- 9) Зураг төсөлд магадлал хийх ажил
- 10) Логистикийн төвд шаардлагатай 2 ширхэг вандан краны нийлүүлэлт, угсралт, туршилт зэрэг ажлуудыг дотоодын гүйцэтгэгч 9 компани, БНХАУ-ын 1 компани хийж гүйцэтгээд байна.

3. Логистикийн төвийн төмөр замын дохиолол холбооны байгууламжид релейн цахилгаан төвлөрүүлэлтийг суурилуулахаас татгалзаж, микропроцессорын цахилгаан төвлөрүүлэлтийн системийг суурилуулахаар шийдсэн тул дохиолол холбооны зураг төслийн ажлыг шинэчилж хийлгэхээр болсны дагуу Төмөр замын дохиолол холбооны зураг төсөл болон угсралтын ажлыг цогцоор нь гүйцэтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах тендерийг зарлан, шалгарсан “Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп” компанитай ЗТХЯ ажил гүйцэтгэх гэрээг 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан. Гүйцэтгэгч компани гэрээнд заасан хугацаа буюу 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдөр төмөр замын дохиолол холбооны барилга угсралтын ажлыг 100% хийж дуусгасан.

4. Логистикийн төвийн барилга байгууламж, төмөр зам, төмөр замын дохиолол, холбоо, вандан краны угсралт, суурилуулалтын ажил дууссантай холбогдуулан барилга байгууламжийг ашиглалтад оруулах 32 гишүүний бүрэлдэхүүнтэй техникийн комисс 2018 оны 12 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд логистикийн төвийн талбайд ажилласан.

Техникийн комиссын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн дотор арилгаж дуусгахыг ТХН, гүйцэтгэгч “Хятадын төмөр замын 21-р товчоо групп” компани, Хяналтын зөвлөх “Сусон инженеринг” компани, “Эн Би Си Си” ХХК, “Геозураглал” ХХК-иудын хамтарсан түншлэл, вандан кран нийлүүлэх, угсрах, турших ажлын гүйцэтгэгч “Хэнань Дафан Хэви Машинери” ХХК-иудад тус тус үүрэг болгосон.

Тус үүрэг даалгаврын дээр дурдсан холбогдох газрууд хамтарч ажилласны дүнд шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг тогтсон хугацаанд амжилттай засаж ажиллалаа.

5. Логистикийн төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп” компани ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажил 100%-тай хийгдэж дуусаад байна.

6. Мөн логистикийн төвийн нийт барилга угсралтын ажил бүрэн хийгдэж дууссантай холбогдуулан ЗТХЯ-наас “Логистикийн төвийн төмөр зам, төмөр замын дохиолол холбооны байгууламж, барилга байгууламж, эрчим хүч, ус хангамжийн байгууламж, бусад нэмэлт ажлуудын угсралт, суурилуулалтын ажил” дууссан тухай захиалагчийн албан ёсны мэдэгдлийн дагуу байнгын ашиглалтад оруулах Ажлын хэсгийг 47 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тус улсын комисс

2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр логистикийн төвд ажилласан. Улсын комиссоос зарим нэг ажилд зөвлөмж өгснөөр логистикийн төвийг ашиглалт оруулах зөвшөөрлийг гаргасан.

7. Логистикийн төвийн барилга угсралтын ажилд хяналт тавих зөвлөх компаниар “Сусонг Инженеринг” компани ажиллаж байна. Тус ажлын гэрээ дүгнэх хурал ЗТХЯ-нд 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр болж зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний хугацааг 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл сунгасан.

8. ТХН-ээс төмөр замын өргөн болон нарийн царигийн трассын газар эзэмших гэрчилгээний хугацааг сунгуулахаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын газрын албатай хамтран ажиллаж байна.

Мөн ТХН-ээс Дорноговь аймгийн Замын-Үүд сумын газрын албатай хамтарч ажилласны дүнд дараах 8 газар эзэмших гэрчилгээг ЗТХЯ-ны нэр дээр гаргуулан авч газар эзэмших гэрээг байгуулсан болно. Үүнд:

- Холбооны шилэн кабелийн 4,15 км трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342915;
- 110 кВ-ын ЦДАШ-ын 4,22 км трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342920;
- Эрчим хүчний дэд өртөөний зориулалтаар ашиглах 4200 м2 газар гэрчилгээний дугаар 000342921;
- Өргөн царигийн төмөр замын 2,4 км трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342916;
- Нарийн царигийн төмөр замын 0,6 км трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342917;
- Цэвэр ус дамжуулах 3.5 км шугамын трассын дагуу газар гэрчилгээний 000342823;
- Цахилгаан дамжуулах 35/0,4 кВ-ын 3 км шугамын трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342824;
- 1,6 км авто зам гүүрийн трассын дагуух газар гэрчилгээний дугаар 000342820;
- Мөн гэрээний хугацаа дууссан газруудын хугацааг сунгасан.

9. Логистикийн төвийн доторх барилга байгууламжийн зураг төсөлд Гаалийн Ерөнхий газрын холбогдох албан тушаалтнуудаас санал авч Гаалийн барилга байгууламж хяналтын талбайг зураг төсөлд тусгасан болно.

10. Хилийн боомт орчим газарт үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг Хил хамгаалах ерөнхий газраас гаргуулж ажилласан.

11. ТХН нь төслийн үйл ажиллагааны явцын тайланг сар, жил, улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар тогтмол гаргаж, тогтсон хугацаанд захиалагч тал болох ЗТХЯ, санхүүжүүлэгч тал болох АХБ-нд хүргүүлж ажилласан.

12. Төслийн гүйцэтгэгч компаниудтай байгуулсан гэрээ болон ТХН-ийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээг дүгнэх 2018 оны ээлжилт хурал 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ЗТХЯ-нд зохион байгуулагдсан.

<p>2-р зорилтын хүрээнд:</p> <p>Үндэсний зам, тээврийн сүлжээг өргөжүүлэх, олон улсын тээврийн системтэй холбох,</p> <p><u>Хүрэх үр дүн:</u> Ложистикийн төв нь тус төслийн хүрээнд баригдах авто замаар Замын-Үүд-Улаанбаатар чиглэлийн авто зам буюу Азийн босоо тэнхлэгийн АН-3 корридортой холбогдоно.</p>	<p>13. Логистикийн төвийг Азийн босоо тэнхлэгийн АН-3 корридортой холбох Төмөр замтай 2 түвшинд огтлолцох гүүрэн байгууламж болон 1,6 км авто замын барилга угсралтын ажил 100% хийгдэж дууссан.</p> <p>14. Логистикийн төвийн төмөр замын зураг төслийг шинэчлэн сайжруулсан бөгөөд Төслийн хүрээнд баригдах 11,5 км урттай өргөн болон нарийн царигийн салбар төмөр зам баригдаж дуусаад байна. Энэ замыг барьснаар Хятад улсаас нарийн царигийн төмөр замаар орж ирсэн ачааг Улаанбаатар төмөр замын өргөн царигийн төмөр зам руу шилжүүлэн ачих, мөн өргөн болон нарийн царигийн төмөр замаас авто зам руу, авто замаас буцаагаад төмөр зам руу шилжүүлэн ачих боломж бүрдэж байгаа юм.</p> <p>15. Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс орон нутгийн холбогдох газруудтай нягт хамтран ажиллаж ирсэн бөгөөд Дорноговь аймгийн Засаг дарга, Замын-Үүд сумын Засаг дарга нартай удаа дараа уулзалт зохион байгуулж тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж ажилласан.</p> <p>16. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 3-р багийн АН3 босоо тэнхлэгийн авто замын төгсгөлийн дөрвөн замын уулзвараас хүнд даацын авто зам хүртэлх 0.657 км авто зам болон уг 0.657 км авто замаас Замын-Үүд хүртэлх 3.69 км авто замын ажлыг (2 замын нийт төсөв 4,158,232,572 төгрөг) хийх саналыг орон нутгаас ЗТХЯ-нд гаргасан бөгөөд тухайн үеийн ЗТХ-ийн сайдаас уг асуудлыг авч үзээд дэмжиж, санхүүжилтийн асуудлыг судлах чиглэл өгсөн.</p> <p>Харин тус замын ажлын санхүүжүүлэлтийн хувьд төслийн “Зээлийн хөрөнгийн хуваарилалт, ашиглалт”-ын 1 дэх ангилал болох “Ажил”-д дээрх санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцэхгүй байгаа тул “Зээлийн хөрөнгийн хуваарилалт, ашиглалт”-д дахин хуваарилалт хийх шаардлага үүсээд байсан юм.</p> <p>Энэхүү асуудлын хүрээнд ЗТХЯ-аас СЯ-аар дамжуулан АХБ-нд хүсэлт гаргасан бөгөөд АХБ-наас 03 Хуваарилагдаагүй хөрөнгийг 01 Ажил гэсэн хэсэг рүү шилжүүлэх санхүүжилтийн хуваарилалтыг хийж ирүүлээд байгаа. Энэхүү Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 3-р багийн АН3 босоо тэнхлэгийн авто замын төгсгөлийн дөрвөн замын уулзвараас хүнд даацын авто зам хүртэлх 0.657 км авто зам болон уг 0.657 км авто замаас Замын-Үүд хүртэлх 3.69 км авто замын ажил мөн 42,096.77 ам.долларын үнэ бүхий цайны газрын тоног төхөөрөмж, оффисын тавилга худалдан авах ажлын улмаас ЗТХЯ болон СЯ-аас тавьсан хүсэлтийн дагуу АХБ-наас “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн дуусах хугацааг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгаад байна.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>Худалдаа, тээвэр, Логистикийн үйлчилгээг хөнгөвчлөхөд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг нэвтрүүлэх,</p>	<p>17. Логистикийн төвийн гадна холбоо интернетийн шугамын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан бөгөөд шалгарсан “Лийд линк” ХХК-тай 2014,9,2-ны өдөр ЗТЯ (тухайн үеийн нэршлээр)-аас ажил гүйцэтгэх гэрээг байгуулж гэрээт хугацаанд ажил 100% хийгдэж дууссан.</p>

	<p><u>Хүрэх үр дүн:</u> Төслийн хүрээнд баригдах ложистикийн төвийн үйл ажиллагаа нь сүүлийн үеийн программ хангамжаар зохицуулагдах боломж бүрдэх юм.</p>	<p>Тус Лийд Линк компанийн “Холбооны 24 дэх худаг, 100 метр урттай 2 яндант сувагчлал, шилэн кабелийн төгсгөлийн PDF төхөөрөмж, шилэн кабелийн медиа конвертор, жампер кабель, 100 хосын холбооны терминал бокс, хананы хайрцаг” зэргийг нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын баталгаат хугацаа 2018 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр дуусгавар болсон тул уг ажлын гүйцэтгэлийн баталгааны 5 хувь болох 18,506.281.45 төгрөгийг чөлөөлүүлэх хүсэлтийг ЗТХЯ-д гаргасан ба ТХН-ээс судалж үзээд гэрээнд заагдсан дутуу ажлуудыг “Хятадын төмөр замын 21-р товчоо групп” компаниар хийлгэх шийдвэрийг гаргаж ЗТХЯ-д мэдэгдсэн.</p> <p>18. Логистикийн төвд АХБ-ны зээлээр санхүүжигдэх төмөр замын дохиолол холбооны зураг төсөл болон угсралтын ажлыг цогцоор нь гүйцэтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах тендерийг 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр өдөр тутмын хэвлэл болон АХБ, ЗТХЯ-ны цахим хуудсанд байршуулан зарласан бөгөөд 11 компани тендерийн бичиг баримт худалдаж авснаас 5 компани тендэрт оролцож БНХАУ-ын “Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп” компани шалгарч ЗТХЯ-наас ажил гүйцэтгэх гэрээг 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр байгуулж, гэрээнд заасан хугацаанд ажлаа амжилттай гүйцэтгээд байна.</p> <p>“Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп” компанийн ЗТХЯ-тай байгуулсан CW2015/40 гэрээг дүгнэх хурал ЗТХЯ-нд 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр болж тус гэрээний хугацааг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр сунгасан.</p> <p>19. Логистикийн төвийн диспетчерийн холбоо, чанга яригчийн холбоо, паркийн холбоо зэрэг нь орчин үеийн тоон технологид суурилсан болно.</p>
7.	<p>Дүгнэлт (төслийн хэрэгжилтэд хүндрэл үүсгэж байсан болон цаашид анхаарах асуудлууд)</p>	<p><u>Төслийн хэрэгжилтэд хүндрэл үүсгэж байсан асуудлууд</u></p> <p>20. ТЭЗҮ болон ажлын зураг хангалттай түвшинд боловсруулагдаагүйгээс үүдэн ажлын тоо хэмжээнд зөрүү гарах хүндрэл үүсч байсан.</p> <p>21. Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн СМЕК компанийн ажлын даалгаварт зайлшгүй шаардагдах инженер техникийн болон зарим ажилтнуудыг дутуу тусгаснаас хүндрэлтэй байдал үүсч байсан.</p> <p>22. СМЕК компанийн гэрээний хугацаа 2015 оны 2 сард дууссан бөгөөд гэрээний үргэлжлэх хугацаатай холбогдуулан маргаантай асуудлууд нэлээдгүй үүссэн.</p> <p>Уг асуудлын хүрээнд захиалагч тал болох ЗТХЯ, санхүүжүүлэгч тал болох АХБ, СМЕК зөвлөх багийн удирдлагууд 2016 оны 6 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотноо уулзалт хийж, талууд зөвшилцөн харилцан ойлголцож “Санамж бичиг” байгуулсан.</p> <p>Санамж бичигт тусгасны дагуу СМЕК зөвлөх компаниас Гэрээний хүрээнд хийгдсэн зарим ажлын болон нэмэлт ажлын зардал болох 500,000.00 ам.долларыг төслийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэж 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдөр</p>

санхүүжилт хийгдэж маргаантай байсан асуудал эцэслэн шийдэгдсэн болно.

23. ТХН-ээс “Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп” компанийн ЗТХЯ-тай байгуулсан CW2015/40 тоот барилгын ажлын гэрээнд өөрчлөлт оруулах /1-2-р өөрчлөлт/-аар 2016 оны 8 дугаар сарын 30-ны өдрөөс эхэлж ажилласан бөгөөд уг өөрчлөлт 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдөр ЗТХЯ-наас эцэслэн баталгаажсан.

Мөн тус CW2015/40 тоот барилгын ажлын гэрээнд 3 дахь удаагаа өөрчлөлт оруулахаар ТХН-ээс ЗТХЯ, АХБ-тай хамтран ажиллаж байна.

24. Засгийн газрын “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай” тогтоолын төслийг 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг гаргуулж ажиллав. Мөн ТХН-ээс Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргатай хамтран ажиллаж “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах” зөвшөөрлийг гүйцэтгэгч “Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп” компанийн нэр дээр гаргуулж ажилласан.

Тус ашигт малтмал буюу барилга угсралтын ажилд хэрэглэсэн хайрганы асуудлаар ТХН орон нутгийн удирдах байгууллага, ЗТХЯ-тай тогтмол холбоотой ажиллаж асуудлыг шийдвэрлүүлж ажилласан.

25. Замын-Үүд сумын оршин суугчдын хог хаягдлын талбайг Логистикийн төвийн нарийн царигийн төмөр замын трасс дайран өнгөрч байгаатай холбогдуулан хогийн цэгийг цэвэрлэж, нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болсон.

Иймд Замын-Үүд сумаас тавьсан хүсэлтийн дагуу АХБ-аас зөвшөөрөл авч, тус хогийн цэгийг булшилж, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардлагатай дунд оврын дугуйт экскаватор “НТЛ80”, хүнд даацын өөрөө буулгагч самосвал “НОВО 290” маркийн 2 машин техникийг Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газарт авч өгсний үндсэн дээр хогийн цэгийг дарж булшлах ажил хийгдсэн.

26. Логистикийн төвийн барилгын ажилд хэрэглэсэн ашигт малтмалын төлбөрийг гүйцэтгэгч компани төлж дууссан бөгөөд Замын-Үүд сумын Засаг даргын зүгээс 2018 оны 10 дугаар сард тус төсөлд ашиглагдсан шороон ба хайрганы карьерыг орон нутгийн хэрэгцээнд зориулан цаашид үргэлжлүүлэн ашиглах тул нөхөн сэргээлт хийлгүйгээр орон нутгийн засаг захиргаанд шилжүүлэн өгөх саналыг албан бичгээр тавьсан.

ТХН-ийн зүгээс уг хүсэлтийг судлан үзээд холбогдох хууль тогтоомжтой харшлах зүйл байхгүй гэж үзэн ЗТХЯ ба АХБ-наас зөвшөөрөл авахаар хандсан болно.



27. Тус логистикийн төсөл хэрэгжиж буй Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багийн нутаг дэвсгэр дэх 400 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж өгөх хүсэлтийг ЗТХЯ-наас гаргаад байгаа билээ.

Уг асуудлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн Сайдаас төслийн хэрэгцээнд ашиглаж байгаа газрыг Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад заасны дагуу улсын тусгай хэрэгцээнд авах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон холбогдох материалуудын хамтаар Монгол Улсын Засгийн газрын гишүүдэд 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр хүргүүлсэн болно.

28. Тус логистикийн төсөл хэрэгжиж буй Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багийн нутаг дэвсгэр дэх 400 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж өгөх хүсэлтийг ЗТХЯ-наас гаргасан ба уг асуудлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн Сайдаас төслийн хэрэгцээнд ашиглаж байгаа газрыг Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад заасны дагуу улсын тусгай хэрэгцээнд авах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон холбогдох материалуудын хамтаар Монгол Улсын Засгийн газрын гишүүдэд 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр хүргүүлсэн.

Үүний хариуд Сангийн яам, Барилга хот байгуулалтын яамнаас тус газрыг улсын тусгай хэрэгцээнд авах нь зүйтэй гэсэн хариу ирүүлсэн. ТХН-ээс дээрх ажлын хүрээнд газрын кадастрын зургийг бэлтгэх болон санал авахаар Засгийн газрын тогтоолын төслийг бэлтгэж ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Сангийн яам, Барилга хот байгуулалтын яам /БХБЯ/-наас тус газрыг улсын тусгай хэрэгцээнд авах нь зүйтэй гэсэн хариу ирүүлсэн. Үүний дагуу Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар /ГЗБГЗЗГ/-аас ГЕГ-ын Боомтын хөгжлийн хэлтэс болон Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газраас холбогдох саналыг авах албан бичгийг 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр хүргүүлсэн.

Улмаар дээрх 400 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд шилжүүлэх Дорноговь аймгийн ИТХ-ын тогтоол 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр гарч тогтоолыг ЗТХЯ-наас 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдөр албан бичгээр БХБЯ-нд уламжилсан. БХБЯ-наас өгсөн чиг үүргийн дагуу ГЗБГЗЗГ-аас Засгийн газрын тогтоолын төслийн иж бүрдэлд орох тухайн газрын ерөнхий байдлын дүгнэлтийг авахаар Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газарт 2018 оны 12 дугаар сард албан бичгээр хандаад байна.

Төслийн хэрэгжилтийн явцад зайлшгүй анхаарах шаардлагатай доорх асуудлууд байна. Үүнд:

			<p>29. Төслийн хэрэгцээний зориулалттай 400 га газрыг Дорноговь аймгийн ИТХ-аас дуудлага худалдаанд оруулахаар төлөвлөж буйг зогсоож, Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг шийдвэрлүүлэх.</p>		
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		<p>30. ТХН-ээс Захиалагч тал болох ЗТХЯ, санхүүжүүлэгч тал болох АХБ, барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй нягт хамтарч ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Захиалагч талд төсөл хэрэгжих явцын сар улирал, хагас жил, жилийн эцсийн тайлангуудыг тогтсон хугацаанд хүргүүлсэн. - АХБ-нд төсөл хэрэгжүүлэх явцын үйл ажиллагааны тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэн тогтсон хугацаанд хүргүүлсэн бөгөөд АХБ-наас зохион байгуулсан уулзалт, сургалтад хамрагдаж, ТХН-д тулгамдаж буй асуудлыг танилцуулан зөвлөмж зөвлөгөө авч ажиллаж байна. <p>31. Мөн төслийн гүйцэтгэгч болон зөвлөх компаниудын ажлын явцын тайланг тогтсон хугацаанд авч хянан ЗТХЯ, АХБ-нд хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>32. ТХН-ийн Байгаль орчин, нийгмийн хөгжлийн мониторингийн /БОНХМ/ тайлангуудыг бэлтгэж АХБ болон ЗТХЯ-нд хүргүүлсэн. Төслийн зүгээс холбогдох хууль тогтоомж болон төслийн БОМТ-нд заагдсан байгаль орчин, нийгмийн үүрэг хариуцлагаа 2018 онд хангалттай түвшинд биелүүлж ажилласан.</p> <p>33. ТХН-ээс гүйцэтгэгчид, зөвлөх багаас гадна захиалагч санхүүжүүлэгч талуудтай нягт хамтран ажиллаж төслийн хэрэгжилтийн явцад үүссэн тулгамдсан болон маргаантай асуудлуудыг нааштайгаар шийдвэрлүүлж ажиллаа.</p> <p>34. АХБ-ны суурийн төлөөлөгчийн газраас 2018 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Төсөл хөтөлбөрүүдийн дунд зохион байгуулсан хурлаас тус “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийг 2018 оны хамгийн шилдэг гүйцэтгэлтэй төслөөр шалгаруулаад байна.</p>		
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		100%	100%	100%	100%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	хөтөлбөрийн нэгдсэн	Нэгдсэн үнэлгээ		
			100%		

Тайлбар:

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын Хавсралт 5